



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Хүнс, хөдөө, аж ахуйн сайдын төсвийн багцын
2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/33/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер Ц.Ойдов
Утас: 260512
Цахим хаяг:
oidovts@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Батсайхан
Цахим хаяг:
batsaikhann@audit.gov.mn
Утас: 261885

Шинжээч Н.Нямдаваа
Цахим хаяг:
nyamdavaan@audit.gov.mn
Утас: 261885

Үндэсний аудитын газар

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон
нарийвчилсан горим, түүний үр дүн
Материаллаг байдлыг тооцсон тухай
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх
тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын
талаарх тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн
зөрчлийн нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх
дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Хавсралт 4: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд /YAГ-2015/33/CTA-TE3/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 09-нөөс 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын VI багийн ахлах аудитор Н.Батсайхан, шинжээч Н.Нямдаваа нар хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 3-нд 01/952 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2015 оны 4 дүгээр сарын ...-нд Хүнс хөдөө аж ахуйн сайдад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Хүнс, хөдөө аж ахуйн яамны төсвийн ерөнхийлөн захирагч нь “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, бусад холбогдолтой хууль, эрх зүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын гол зорилго нь салбарын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, нөөцөд суурилсан нэмүү өртгийн сүлжээг дэмжих, импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

Тус яам нь улсын хэмжээний хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх улсын хэмжээний бодлогыг хэрэгжүүлэн, түүнийг удирдан чиглүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна

Дээрх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор төрийн захиргааны төв байгууллагын төсвийн” ерөнхийлөн захирагч байна гэж заасны дагуу тус яамны Сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлангийн уялдаа тохиргоог шалгаж, мөнгөн гүйлгээний зарим дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 14-ийг гүйцэтгэв.

Тухайн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ҮХААС-ын 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан яамны салбарын хэмжээний үйл ажиллагаанд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдлөгө болгон ажилласан байна. Ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэлийн програм нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, УСНББОУС-тай нийцсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт хөрөнгийн 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 5.9 тэрбум төгрөг гэж тооцсон. Нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин бага гарч байгаа хэдий ч зээл олголт ихтэй, авлага, өглөгийн түвшин өндөр байдаг уламжлалт эрсдлийг үндэслэн нийт хөрөнгийн хоёр хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзсэн ба гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцоолоогүй болно.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хүнс, хөдөө аж ахуйн яамны аппаратын ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг бага гэж тооцсон ба дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны төсвийн ерөнхийлөн захирагч нь 2014 онд улсын төсвөөс 130.3 тэрбум төгрөгийн, гадаадын тусламжаас 2.1 тэрбум төгрөг, тусгай сангаас 4.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 16.5 тэрбум төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 0.7 тэрбум төгрөг, хүүгийн орлого 0.4 тэрбум төгрөг оруулсан ба урсгал зардалд 146.6 тэрбум төгрөг батлагдсанаас 153.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо хангах хүрээнд тус яам өөрийн цахим хуудсаар <http://shilendans.gov.mn/main/agency/1025> байршуулсан байна.

- Төсвийн гүйцэтгэл цэсэнд: ТЕЗ-ийн 3 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг жагсаалтаар, график болон татаж авах файл хэлбэрээр байршуулсан байна.
- Таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 1 дүгээр сараас 4 дүгээр сар 9-ны хооронд гарсан ажил гүйлгээ тус бүрээр байшуулсан.
- Хөрөнгө оруулалт цэсэнд: Хөрөнгийн болон концессын зүйлийн зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр жагсаалтаар болон графикаар байршуулсан.
- Тендер болон худалдан авалт цэсэнд: Тендерийн ерөнхий мэдээлэлд 6 тендерийг батлагдсан төсөвт өртгийн хамт жагсаалт, график болон татаж авах файл хэлбэрээр байршуулжээ. Мөн таван сая төгрөгнөөс дээш худалдан авалтаар дээрх 6 тендерийн гэрээний дүн, санхүүжилтын хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягыг байршуулсан байна.

ХХААЯам нь шилэн дансны хуулийг хэрэгжүүлж удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа, мэдээ мэдээллээ өөрийн цахим хуудаснаа байршуулан ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитаар 18 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 38 нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлвол: ХХААС-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын үлдэгдэл 159.0 тэрбум төгрөг байгаа нь нийт хөрөнгийн 53.6 хувийг эзлэж байна. Нийт авлагын 65.9 хувь буюу 104.9 тэрбум төгрөг нь зээлийн авлага бөгөөд үүнээс 69.8 тэрбум төгрөг буюу 66.5 хувь нь хугацаа нь хэтэрсэн, 63.3 тэрбум төгрөг буюу 60.3 хувийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь дээр дурьдсан эрсдэл бий болох нөхцөл бүрдсэн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, жилийн эцсийн аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүнд харьцуулсан, зэрэгцүүлсэн дүн шинжилгээ хийж, зарим томоохон дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэн шалгалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 32 байгууллага, 6 төслийн нэгж, 11 хөтөлбөр арга хэмжээний санхүүгийн тайлан нэгтгэгдснээс 33 санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гарснаас Говь-Алтай, Өвөрхангай, Ховд аймгуудын ХХААГ-ууд, ТЭДС зэрэг 4 байгууллагын санхүүгийн тайлан хязгаарлалттай, бусад 27 тайлан зөрчилгүй санал дүгнэлтийг тус тус авсан байна.

Аудитаар нийт 223.6 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 14.5 тэрбум төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 19.1 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 65.3 тэрбум төгрөгийн албан шаардлага, 143.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд тэмдэглэл бэлтгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 32 тоот тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал"-ыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 32 тоот тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал"-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

2. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан төсвийн байгууллага, төсөл, сангийн аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн дүнг тулган шалгахад 1.1 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн

тайлан УСНББОУС 6-д нийцээгүй ба үнэн зөв байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад тайлбар гарган тухайн байгууллагын аудитлагдсан тайланг залруулав.

3. Санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын задаргааг шалгахад 91.5 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг зардлын тооцооны авлагаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "бүртгэл, тайлангийн үзүүлэлт энгийн, тодорхой, ойлгомжтой байх" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлан илчлэл ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

4. 2015 онд Сангийн Сайдын 19, 55, 92 тоот тушаалууд гарч 2014 онд төсөвт татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлийг буцаан олгох байгууллагуудын жагсаалтыг гаргаж баталсан байгаагаас ХХААС-ын багцад хамрагдах 21 байгууллагаас 9 байгууллага 0.4 тэрбум төгрөгийн авлагыг данс бүртгэлдээ тусгаж тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

5. Авлагын тооцоолол, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байдлыг тулган шалгахад 69.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, 63.3 тэрбум төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Асуудлын бүртгэлээр холбогдох удирдлагуудад танилцуулж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

6. Нийт 132.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаагаас 84.9 тэрбум төгрөг буюу 64.2 хувь нь зээлийн өр байна. Нийт 31.5 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 32.9 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Бага оврын трактор худалдан авах төслийн гадаад зээлийн үлдэгдэл өмнөх оноос 13.8 тэрбум төгрөгөөр өссөн нь валютын ханшийн зөрүү байна. Мөн ОБЕГ-д төлөх шатахууны өрийн үлдэгдэл 4.2 тэрбум төгрөг нь тооцоо нийлсэн актаас 1.7 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ТЭДС шатахууны зах зээлийн үнээр бүртгэж өглөгөд тусгасан, ОБЕГ тухайн үеийн өртгөөр нь бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Асуудлын бүртгэлээр холбогдох удирдлагуудад танилцуулж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Илэрсэн алдааг аудитын явцад залруулж тайлагнасан тул залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, КР-1, КР-2, Бага оврын тракторын зээлийн төслийн нэгжүүдээр олгогдож буй зээлүүдийн эргэн төлөлт хангалтгүй,

зарим борлуулах зорилгоор худалдан авсан тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийн борлуулалт муу, үнийн бууралтаас жил тутам ихээхэн хэмжээний алдагдал хүлээдэг, хадгалалт, хамгаалалтын зардал өндөр гарч байгаа, валютын ханшийн алдагдал хүлээж байгаа зэрэг нь төсвийг ихээхэн хэмжээний алдагдалд оруулж, төсвийн хөрөнгийг үнэгүйдүүлэх хүндрэлд оруулж болзошгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал Бага оврын тракторын зээлээр нийт 27.9 сая ам.долларын үнэ бүхий 8400 ширхэг тракторыг хадуур тармуур, анжисын хамт худалдан авч 2012 оноос эхлэн зээлээр 4061 ширхэг буюу 48.3 хувийг борлуулж, 2014 оны жилийн эцсийн байдлаар 4339 ширхэг тракторын үлдэгдэлтэй байна. Бага оврын тракторын борлуулалт муу байгаа тул дахин 0.9 тэрбум төгрөгийн дагалдах техник хэрэгслийг худалдан авсан ба хадгалалтын зардалд жилд 72.0 сая төгрөгийн зардал гарч, тайлант онд 13.7 тэрбум төгрөгийн валютын ханшийн алдагдал хүлээсэн байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 8 зөвлөмж өгөгдснөөс 2 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

1. Өмнөх аудитаар Сангийн яаманд МУХС-ын хөрөнгөөр улаан буудай авсан 27.3 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэл Төв төрийн сангийн үлдэгдэлтэй зөрүүтэй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаад Сангийн яамнаас ажлын хэсэг гаргаж ажилласан боловч тодорхой шийдэлд хүрээгүй байна.
2. МХС “Гацуурт” ХХК-иас авах 3.0 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах талаар зөвлөмж өгсөн боловч одоог хүртэл тооцоо нийлээгүй. Энэ тухай Гацуурт ХХК-тай үүссэн 2.0 тэрбум төгрөгийн хувьд 2012 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 45-ын “Махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр импортолж, үржлийн аж ахуй байгуулах” хөрөнгө оруулалтын гэрээг хүчингүй болгож 2013 оны 12-р сарын 23-нд ҮХААЯ-ны ТНБД-ийн ХАГ20131220-001 тоот зээлийн гэрээ болгон өөрчилсөн. Гэрээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Гацуурт ХХК нь дээрх тооцоог хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлсэн. Тооцооны үлдэгдлийн баталгаа нийлэх талаар Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тоот нэг удаа, Мал хамгаалах сангийн захирлын албан тоот мөн нэг удаа хүргүүлж, биечлэн 2 удаа, мөн утсаар хэд хэдэн удаа холбогдож уулзсан боловч одоог хүртэл албан ёсны хариу өгөөгүй байна. Цаашид дараагийн шатны арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөөд байна гэсэн тайлбар өгөв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан болон

илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД Р.БУРМАА ТАНАА

2015.04.24 № 800
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1:

Асуудал 1

Авлагын талаар

Асуудал 2

Өр төлбөрийн талаар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт:

Авлагын тооцоолол, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байдлыг тулган шалгахад 69.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, 63.3 тэрбум төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл:

Өр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт:

Нийт 132.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаагаас 84.9 тэрбум төгрөг буюу 64.2 хувь нь зээлийн өр байна. Нийт 31.5 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 32.9 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Бага оврын трактор худалдан авах төслийн гадаад зээлийн үлдэгдэл өмнөх оноос 13.8 тэрбум төгрөгөөр өссөн нь валютын ханшийн зөрүү байна. Мөн ОБЕГ-д төлөх шатахууны өрийн үлдэгдэл 4.2 тэрбум төгрөг нь тооцоо нийлсэн актаас 1.7 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ТЭДС шатахууны зах зээлийн үнээр бүртгэж өглөгөд тусгасан, ОБЕГ тухайн үеийн өртгөөр нь бүртгэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх /эрх ба үүрэг/

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	ЗАЛРУУЛГА	АУДИТ ХИЙГДСЭН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,546,000,511.66	14,270,224,371.70		14,270,224,371.70
Кассанд байгаа бэлэн мөнгө	9,717,812.56	2,202,122.35		2,202,122.35
Төгрөг\ ЖМС	9,701,156.56	2,202,122.35		2,202,122.35
Нэмэлт санхүүжилтийн касс	16,656.00			0.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	7,536,282,699.10	14,268,022,249.35		14,268,022,249.35
Төгрөг	7,536,282,699.10	14,268,022,249.35		14,268,022,249.35
Тусгай зориулалтын сангийн харилцах	6,989,683,458.35	14,265,139,368.18		14,265,139,368.18
Нэмэлт санхүүжилтийн харилцах	546,599,240.75	2,882,881.17		2,882,881.17
АВЛАГА	168,838,151,947.07	158,960,300,330.71	411,714,191.50	159,372,014,522.21
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,035,343.08	81,548,874.05		81,548,874.05
Төлбөртэй үйлчилгээний авлага	22,471,803.67	811,940.67		811,940.67
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	250,024,726.13	201,663,534.35	1,066,214,470.72	1,267,878,005.07
Бусад авлага	152,197,239,717.68	145,248,061,044.62	(123,691,143,451.30)	21,556,917,593.32
Байгууллагаас авах авлага	152,194,882,054.62	145,159,867,516.62	(123,691,143,451.30)	21,468,724,065.32
Гэрэл цахилгааны авлага	1,150,000.00			0.00
Түлш халаалтын авлага	2,742,540.00	1,805,835.00		1,805,835.00
Дотоод албан томилолтын авлага		620,000.00		620,000.00
Бусад зардлын тооцооны авлага	152,190,989,514.62	145,157,441,681.62	(123,691,285,990.30)	21,466,155,691.32
Хувь хүмүүсээс авах авлага	2,357,663.06	88,336,067.00		88,336,067.00
Зээлийн авлага	16,367,380,356.51	13,428,214,937.02	123,036,643,172.08	136,464,858,109.10
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	16,367,380,356.51	13,428,214,937.02	123,036,643,172.08	136,464,858,109.10
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	3,558,223,960.00			0.00
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	12,809,156,396.51	13,428,214,937.02	123,036,643,172.08	136,464,858,109.10
УРЬДЧИЛГАА	82,010,000.00	48,544,729.35		48,544,729.35
Бусад урьдчилгаа	82,010,000.00	48,544,729.35		48,544,729.35
Урьдчилж гарсан зардал	82,010,000.00	48,544,729.35		48,544,729.35
Урьдчилж төлсөн зардал	82,010,000.00	48,544,729.35		48,544,729.35
БАРАА МАТЕРИАЛ	51,806,104,730.20	57,650,085,500.39		57,650,085,500.39
Түүхий эд материал	47,706,917,145.83	51,782,722,246.51		51,782,722,246.51
Тусгай зориулалттай материал	32,939,080,023.61	28,547,468,433.38		28,547,468,433.38

Эм боох материал	2,396,889,212.15	2,323,714,062.21		2,323,714,062.21
Дуусаагүй үйлдвэрлэл	160,000,000.00			0.00
Бэлэн бүтээгдэхүүн	12,210,947,910.07	20,911,539,750.92		20,911,539,750.92
Хангамжийн материал	1,688,748,842.75	1,940,495,061.27		1,940,495,061.27
Бичиг хэргийн материал	33,724,958.37	38,680,440.11		38,680,440.11
Аж ахуйн материал	971,981,345.70	1,210,027,549.21		1,210,027,549.21
Сэлбэг хэрэгсэл	33,847,298.30	24,672,113.14		24,672,113.14
Түлш, шатах тослох материал	113,164,517.59	132,844,753.67		132,844,753.67
Барилгын засварын материал	13,604,101.64	11,035,201.24		11,035,201.24
Хүнсний материал	913,700.00	1,088,700.00		1,088,700.00
Малын тэжээл	207,380.00	51,901,500.00		51,901,500.00
Баглаа боодол	215,170.99	215,170.99		215,170.99
Бусад бараа материал	521,090,370.16	470,029,632.91		470,029,632.91
Мал амьтад	1,062,679,878.14	3,252,004,166.50		3,252,004,166.50
Бусад	1,347,758,863.48	674,864,026.11		674,864,026.11
НӨӨЦ		4,022,190.00		4,022,190.00
Бусад нөөц		4,022,190.00		4,022,190.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	228,272,267,188.93	230,933,177,122.15	411,714,191.50	231,344,891,313.65
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	54,881,741,684.11	65,556,954,254.32		65,556,954,254.32
Биет хөрөнгө	54,479,653,229.04	65,419,658,033.50		65,419,658,033.50
Барилга, байгууламж, орон сууц	30,976,596,613.24	27,975,132,377.06		27,975,132,377.06
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	39,968,160,234.83	37,403,868,301.83		37,403,868,301.83
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	-8,991,563,621.59	-9,428,735,924.77		-9,428,735,924.77
Авто-тээврийн хэрэгсэл	4,887,194,557.92	5,414,090,623.64		5,414,090,623.64
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	8,440,916,931.05	9,668,573,102.95		9,668,573,102.95
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	-3,553,722,373.13	-4,254,482,479.31		-4,254,482,479.31
Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,497,641,877.28	16,110,692,768.98		16,110,692,768.98
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	14,512,064,823.70	22,958,059,600.16		22,958,059,600.16
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	-5,014,422,946.42	-6,847,366,831.18		-6,847,366,831.18
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,173,577,303.46	1,635,798,759.86		1,635,798,759.86
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	2,507,138,220.57	3,172,851,610.19		3,172,851,610.19
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	-1,333,560,917.11	-1,537,052,850.33		-1,537,052,850.33
Зам, гүүрийн байгууламж	27,845,100.00	27,845,100.00		27,845,100.00
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	27,845,100.00	27,845,100.00		27,845,100.00
Бусад үндсэн хөрөнгө	3,157,709,817.14	3,876,604,878.96		3,876,604,878.96

Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	4,919,722,319.03	6,103,224,177.73		6,103,224,177.73
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	-1,762,012,501.89	-2,226,619,298.77		-2,226,619,298.77
Дуусаагүй барилга, байгууламж	4,759,087,960.00	10,379,493,525.00		10,379,493,525.00
Биет бус хөрөнгө	402,088,455.07	137,296,220.82		137,296,220.82
Програм хангамж	359,350,399.62	106,988,165.45		106,988,165.45
Програм хангамж - Анхны өртөг	799,122,270.00	604,480,170.00		604,480,170.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	-439,771,870.38	-497,492,004.55		-497,492,004.55
Бусад биет бус хөрөнгө	42,738,055.45	30,308,055.37		30,308,055.37
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	107,709,472.60	107,709,472.60		107,709,472.60
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	-64,971,417.15	-77,401,417.23		-77,401,417.23
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	283,154,008,873.04	296,490,131,376.47	411,714,191.50	296,901,845,567.97
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	125,350,790,755.19	132,224,435,022.89		132,224,435,022.89
Богино хугацаат зээлийн өглөг	39,037,202,400.00	52,664,808,000.00	32,271,176,040.31	84,935,984,040.31
Гадаад валют	39,037,202,400.00	52,664,808,000.00	32,271,176,040.31	84,935,984,040.31
Олон улсын байгууллага	39,037,202,400.00	52,664,808,000.00	32,271,176,040.31	84,935,984,040.31
Төслийн зээл	39,037,202,400.00	52,664,808,000.00	32,271,176,040.31	84,935,984,040.31
Өглөг	85,728,063,806.29	77,716,394,596.67	(32,275,388,290.31)	45,441,006,306.36
Ажилчидтай холбогдсон тооцоо	7,225,422.28	33,739,288.44		33,739,288.44
Цалингийн өглөг	128,044.00	14,912,249.50		14,912,249.50
НДШ-ийн өглөг	3,652,949.00	11,978,927.73		11,978,927.73
ХАОАТ-ын өглөг	2,808,096.00	6,848,111.21		6,848,111.21
ҮЭ-ийн өглөг	636,333.28			0.00
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	2,528,706,985.39	3,416,559,533.56	(662,439,772.89)	2,754,119,760.67
Түлш халаалтын тооцоо		1,433,750.00		1,433,750.00
Шуудан холбооны тооцоо	4,519.50	596,346.00		596,346.00
Бусад зардлын тооцоо	2,528,702,465.89	3,414,529,437.56	(662,439,772.89)	2,752,089,664.67
Бусад өглөг	83,192,131,398.62	74,266,095,774.67	(31,612,948,517.42)	42,653,147,257.25
Байгууллагад төлөх өглөг	83,192,116,264.62	74,243,658,463.48	(31,612,948,517.42)	42,630,709,946.06
Хувь хүмүүст төлөх өглөг	15,134.00	22,437,311.19		22,437,311.19
Урьдчилж орсон орлого	585,524,548.90	1,843,232,426.22	4,212,250.00	1,847,444,676.22
Төсөвт байгууллага	28,837,453.12	24,277,742.12	4,212,250.00	28,489,992.12
Урьдчилж орсон орлого	28,837,453.12	24,277,742.12	4,212,250.00	28,489,992.12
Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар	60,330,000.00			0.00
Бусад урьдчилж орсон орлого	496,357,095.78	1,818,954,684.10		1,818,954,684.10
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	125,350,790,755.19	132,224,435,022.89		132,224,435,022.89
Засгийн газрын хувь оролцоо	157,803,218,117.85	164,265,696,353.58	411,714,191.50	164,677,410,545.08

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	112,757,179,163.80	106,447,055,366.49		106,447,055,366.49
Хуримтлагдсан үр дүн	42,167,853,219.57	54,962,950,690.49	411,714,191.50	55,374,664,881.99
Өмнөх үеийн үр дүн	42,167,853,219.57	42,175,571,550.53		42,175,571,550.53
Тайлант үеийн үр дүн		12,787,379,139.96	411,714,191.50	13,199,093,331.46
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,878,185,734.48	2,855,690,296.60		2,855,690,296.60
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	157,803,218,117.85	164,265,696,353.58	411,714,191.50	164,677,410,545.08
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	283,154,008,873.04	296,490,131,376.47	411,714,191.50	296,901,845,567.97

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЗАЛРУУЛГА	АУДИТ ХИЙГДСЭН ҮЛДЭГДЭЛ
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,447,807,687.73	177,325,205,965.82		177,325,205,965.82
Гадаад орнуудаас үзүүлсэн	5,474,784,787.11	3,261,666,323.85		3,261,666,323.85
Урсгал	4,847,924,629.99	2,142,750,644.71		2,142,750,644.71
Хөрөнгийн	626,860,157.12	1,118,915,679.14		1,118,915,679.14
Олон улсын байгууллагын тусламж		1,890,928,001.38		1,890,928,001.38
Урсгал тусламж		1,890,928,001.38		1,890,928,001.38
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	175,973,022,900.62	172,172,611,640.59		172,172,611,640.59
Улсын төвлөрсөн төсвөөс	156,214,734,466.57	161,462,082,711.92		161,462,082,711.92
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	87,134,407,823.68	130,476,956,930.00		130,476,956,930.00
Төсвийн хуваарилаагүй зардал	125,736,580.30			0.00
Хөрөнгийн	54,815,642,200.89	9,947,020,192.37		9,947,020,192.37
Нэмэлт санхүүжилтийн орлого	14,138,947,861.70	21,038,105,589.55		21,038,105,589.55
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		31,099,487.78		31,099,487.78
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУБ	163,652,900.00	195,639,942.15		195,639,942.15
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	3,891,824,798.00	12,478,960,433.65		12,478,960,433.65
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	9,847,441,913.43	5,617,852,179.70		5,617,852,179.70
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	236,028,250.27	2,713,924,146.27		2,713,924,146.27
Төсвийн урамшуулал		629,400.00		629,400.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	827,041,274.56	730,642,621.00		730,642,621.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	388,723,400.00	295,113,575.00		295,113,575.00
Хөрөнгийн	438,317,874.56	435,529,046.00		435,529,046.00
Төсөвт байгууллагаас	18,901,783,882.49	5,947,539,191.67		5,947,539,191.67
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		105,760,000.00		105,760,000.00
Хөрөнгийн	18,901,783,882.49	5,841,779,191.67		5,841,779,191.67
Нийгмийн даатгалын сангаас	29,463,277.00	32,347,116.00		32,347,116.00
НДС-ийн шилжүүлэг	29,463,277.00	32,347,116.00		32,347,116.00
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих		4,000,000,000.00		4,000,000,000.00

Гадаад төслийн зээлээс санхүүжих		4,000,000,000.00		4,000,000,000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,463,988,014.97	52,557,113,736.03		52,557,113,736.03
Өмчийн орлого		692,260,417.01		692,260,417.01
Хүүгийн орлого		692,260,417.01		692,260,417.01
Бараа, үйлчилгээний борлуулалт	66,604,249,440.90	51,864,853,319.02		51,864,853,319.02
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	66,604,249,440.90	50,997,140,891.31		50,997,140,891.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	42,495,839,357.27	26,162,160,625.37		26,162,160,625.37
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,222,802,412.74	9,274,971,126.45		9,274,971,126.45
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,885,607,670.89	15,560,009,139.49		15,560,009,139.49
Навигацийн орлого		867,712,427.71		867,712,427.71
Тусламжаас бусад шилжүүлэг	10,859,738,574.07			0.00
Өмч хувьчлалын орлого	10,859,738,574.07			0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	258,911,795,702.70	229,882,319,701.85		229,882,319,701.85
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	10,173,657,639.40	10,611,126,174.95		10,611,126,174.95
Үндсэн болон нэмэгдэл цалин	9,135,968,316.71	9,597,296,244.82		9,597,296,244.82
Үндсэн цалин	8,026,174,131.70	8,685,003,334.15		8,685,003,334.15
